

Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн
аюулгүй байдалд тавих шаардлага

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага” (цаашид Аюулгүй байдлын шаардлага гэх)-д Монгол улсын мал аж ахуйн салбарт хэрэглэж буй гол нэр төрлийн мал, амьтны тэжээлийг үйлдвэрлэх, импортлох үеийн аюулгүй байдалд тавих шаардлагыг тогтооно.

Хоёр. Тэжээлд тавигдах шаардлага

2.1. Тэжээл нь. техникийн шаардлага “Өвс MNS 0592:2008”, “Буудайн хивэг. техникийн шаардлага MNS 0961:2008”, “Малын нэмэгдэл тэжээл. техникийн шаардлага MNS 1077:2008”, “Үр тарианы хаягдал. техникийн шаардлага MNS 1080:2008”, “Тэжээлийн үр тариа. техникийн шаардлага MNS 1081:2008”, “Төлийн бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн шаардлага MNS 2607:2008”, “Амьтны гаралтай уурагт тэжээлийн гурил. техникийн шаардлага MNS 0547:2008”, “Дарш. техникийн шаардлага MNS 3466:2008”, “Өвсөн дарш. техникийн шаардлага MNS 3467:2008”, “Үхрийн хүчит багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5647:2006”, “Тахианы бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5929:2008”, “Тахайн бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5930:2008”, “Тугал угжих багсармал тэжээл MNS 4091:1988”, “Хужир MNS 1082:1973”, “Эрдэс нэмэгдэл тэжээл MNS 1083:1970”, “Малын тэжээлийн давс MNS 1786:1973”, “Шүү MNS 1787:1973”, “Уурагт тэжээл MNS 2600:1978”, “Сүрлэн дарш MNS 9470:1983”, “Төрөл бүрийн шимт тэжээл “Сүрлэн дарш MNS 9470:1983”, 4550:1998”, “Рапсын шахдас. Техникийн шаардлага MNS GB 22514 : 2015” стандартын шаардлага хангасан байна;

2.2. Тэжээлийн шимт чанарыг илэрхийлэх тэжээлд агуулагдах уураг, эрдэс бодис, амин хүчил зэргийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээнд хамруулна.

**Гурав. Тэжээл үйлдвэрлэл болон техник тоног, төхөөрөмжид
тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага**

3.1. Тэжээл үйлдвэрлэхэд дараах нөхцөлийг хангана:

1/ тэжээл үйлдвэрлэлд хэрэглэж байгаа түүхий эд нь тухайн тэжээлийн стандартын шаардлагыг хангасан байх;

2/ түүхий эд нь өвөрмөц үнэртэй, хөгцийн ба ялзарсан үнэргүй хортон шавьжийн бохирдолгүй байх;

3/ тэжээлийн шимт чанарыг алдагдуулахгүй байх;

4/ Мал амьтны бие махбодод сөрөг нөлөөгүй байх;

3.2. Тэжээлийг энэхүү шаардлагын 2.1-д заасан стандарт болон холбогдох технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэнэ;

3.3. Тэжээл үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж нь тэжээл үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг техник, тоног төхөөрөмж байх;

3.4. Тэжээл үйлдвэрт гарч болзошгүй гэнэтийн осол, аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор техник, тоног төхөөрөмжийг зохих ёсоор байрлуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохион байгуулалтыг бүрэн хангах;

3.5. Агаар, усыг цэвэрлэх, шүүх төхөөрөмж зэрэг үйлдвэрийн орчин, ажилчдын аюулгүй байдлыг бүрэн хангахуйц тоног, төхөөрөмжөөр үйлдвэрийг тоноглох;

3.6. Технологийн горим, түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанар, хүрээлэн буй орчин, халдвар, ариун цэвэр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах зорилгоор хяналтын системийг нэвтрүүлсэн байх;

3.7. Үйлдвэрлэлийн өдөр тутмын ажил эхлэхийн өмнө ажилтан бүрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулна.

Дөрөв. Тэжээлийн савлагаа, шошгонд тавигдах шаардлага

4.1. Тэжээлийн хаяг, шошгонд хэрэглэгчдэд зориулсан дараах мэдээллийг зайлшгүй тусгана;

- 1/ үйлдвэрлэгчийн албан ёсны нэр, хаяг;
- 2/ үйлдвэрлэсэн он, сар, өдөр;
- 3/ стандартын тэмдэглэгээ;
- 4/ тэжээлийн шимт чанарын мэдээлэл;
- 5/ ашиглах болон хадгалах хугацаа, нөхцөл;
- 6/ тэжээлийн хэрэглээний талаар нэмэлт заавар;

4.3. Тэжээлийн шошгыг нь монгол хэл дээр үйлдэнэ;

4.4. Бүтээгдэхүүний шошгонд хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах үг хэллэг хэрэглэхийг хориглоно;

4.5. Хаяг шошго нь гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр гээгдэхгүй, бат, бөх байна.

Тав. Тэжээлийг хадгалахад тавих шаардлага

5.1. Тухайн нэр төрлийн тэжээлийн чанарыг алдагдуулахааргүй, тэжээлийн онцлогт тохирсон орчин, нөхцөлд хадгална.

Зургаа. Тэжээлийг тээвэрлэхэд тавих аюулгүй ажиллагааны шаардлага

Тэжээлийг “Өвс, тэжээл тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага MNS 5647:2006” стандартын дагуу тээвэрлэнэ.

Долоо. Тэжээл импортлоход тавих шаардлага

- 7.1. Тэжээлийн үр тарианд тавигдах шаардлага
- 1/ үнэр хөгцийн ба ялзарсан үнэргүй байх;
 - 2/ хогт хольц 5,0% -иас ихгүй байх;
 - 3/ төмрийн хольц 1 кг үр тарианд 30 мг-аас ихгүй байх;
 - 4/ үр тариа хортонгоор хордсон бохирдоогүй байх;
 - 5/ пестицид 0,1 мг/ кг –аас ихгүй байх;
 - 6/ өнгө үр тарианы хэвийн өнгөтэй, харлаж өнгө нь хувираагүй байх;
 - 7/ үнэр хөгцийн ба ялзарсан үнэргүй байх;
 - 8/ чийг 15%-иас ихгүй байх;

- 9/ нийт уураг 8%-иас багагүй байх;
- 10/ нийт тослог 2%-иас багагүй байх;
- 11/ нийт эслэг 15%-иас ихгүй байх;

7.2. Хорголжин тэжээлд тавигдах шаардлага

- 1/ гадаад байдал жигд няцлагдсан, сайн хольсон байх;
- 2/ хорголжийн урт 20 мм хүртэл байх;
- 3/ хорголжийн диаметр 10 мм хүртэл байх;
- 4/ үйрэлт 30%-иас ихгүй байх;
- 5/ чийг 15% ихгүй байх;
- 6/ нийт уураг 14% багагүй байх;
- 7/ нийт эслэг 15%-иас ихгүй байх;

7.3. Улаан буудайн хивэгт тавигдах шаардлага

- 1/ хивэгний өвөрмөц амттай исгэлэн хүчиллэг бус амтай байх;
- 2/ажлалт Шүдэнд мэдрэгдэх хатуу хольц (элс,шороо)-гүй байх;
- 3/ чийглэг 6,5% ихгүй байх;
- 4/ үнслэг 6,5 ихгүй байх;
- 5/ эслэг 30 ихгүй байх;
- 6/ цардуул 10% ихгүй байх;
- 7/ цацрагийн бохирдолгүй байх;
- 8/ хортон шавьжгүй байх;

7.4.Багсармал тэжээлд тавигдах шаардлага

- 1/ гадаад байдал түүхий эд жигд холилдсон байх;
- 2/ цайвар бор өнгөтэй байх;
- 3/ хөгцөрч ялзарсан үнэргүй байх;
- 4/ нийт протеин 12% -иас багагүй 12 % багагүй байх;
- 5/ нийт эслэг 8% -иас ихгүй байх;
- 6/ чийг 14%-иас ихгүй байх;
- 7/ шороо тоос 0,1 %-иас ихгүй байх;
- 8/ меламинас 2,5% аас ихгүй байх